



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/029

Чингис хот

М.Цэнгэлд буцалтгүй тусламж олгох тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянмөнх сумын Засаг дарга Мижидийн Цэнгэлийн төрсөн хүүхэд нас барсан тул 500000 /таван зуун мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид зарцуулах 500000 /таван зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010102